

**БАТЛАВ:**

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА ...../А.ЭНХБАТ /

**ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:**

ӨГӨӨМӨР ГАВИЛУУД ХХК-НЫ ЗАХИРАЛ...../М.ХАШБААТАР/



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДӨРВӨЛЖ”  
БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар SGMV-00010/  
/Аж ахуй нэгжийн регистрийн дугаар-3615243/

Хянасан:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ:...../Б.БУЯННЭМЭХ /

Боловсруулсан:

“Өгөөмөр гавилууд” ХХК-НИЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН:...../М.ҮҮРИЙНТУЯА/

## АГУУЛГА

1. Төслийн товч танилцуулга.....
2. Төсөл хэрэгжиж буй талбайн төлөв байдал .....
3. Байгаль орчны үнэлгээ холөогдох зөвшөөрлүүд .....
4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....
5. Төсөл хэрэгжиж буй нутгийн төлөв байдлын товч танилцуулга.....
6. Төслийн болзошгүй нөлөөлөл.....
7. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....
8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт.....
9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....
10. Нөхөн сэргээлт, орчны тохижилтын төлөвлөгөө.....
11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....
12. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....
13. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....
14. Химиин бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....
15. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....
16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....
17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....
18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....


## 1. “ДӨРВӨЛЖ” БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

Уурхайн байршил: Оюу толгойн уурхай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Баян багийн нутагт харьяалагддаг бөгөөд Улаанбаатар хотоос урагш 720 км, Даланзадгад хотоос зүүн тийш 290 км, Ханбогд сумаас зүүн хойт зүгт 4,6 км зайд байрладаг.



Зураг 1. Ордын физик газарзүйн байрлал



Зураг 2. “Дөрөлж” дайрганы ордын байршил

**Ангилал:** “Дөрвөлж барилгын чулууны орд нь дайрга бутлах үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж ажиллана.

**Хэрэгжих хугацаа:** Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон ХөОГ-нд үндэслэн “Өгөөмөр гавилууд” ХХК-нд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших SGMV-00010 дугаар ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дөрвөлж” барилгын чулууны ордыг 2019 оны 05-р сарын 06-ний өдөр 15 жилийн хугацаагаар олгосон.

### **1. Уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал**

Уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож, тусгах зорилт тавилаа. 2023 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийт гучин хоёр сая гурван зуун тавин гурван мянган (32,353,000) төгрөг төсөвлөсөн байна.

**Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал /мян.төг/	Баримтлах хууль, журам стандарт
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд	7.000.000	Агаар, ус, хөрсний холбогдох стандартууд
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Орон нутагтай хамтран тогтооно	11.109.000	"Байгаль орчныг хамгаалах" хууль
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний	Уурхайн бүх хэлтсийн удирдлага ажилчид	1.500.000	Хог хаягдлын стандарт хууль
4	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Уурхайн бүх хэлтсийн удирдлага ажилчид	1.000.00	"Байгаль орчныг хамгаалах" хууль
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Төслийн нөлөөллийн болон нөлөөллийн бус орчин	1.984.000	Агаар, ус, хөрсний холбогдох стандартууд
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Уурхайн олборлолтын талбайд	4.760.0000	MNS 5918:2008 бусад холбогдох стандарт
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Төслийн талбай, уурхайн ажилчид	5.000.000	ХАБ-тай хууль, холбогдох стандарт, журмууд
Нийт зардал			32.353.000	

### **2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**Уур амьсгал:** Уг төслийн талбай орчимд хавар, намартаа сэргүүн, зундаа халуун, өвөлдөө хүйтэн, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Энд хавар нь маш хуурай бөгөөд салхи ихтэй. 1976-2014 оны ажиглалтын мэдээнээс үзэхэд тус бус нутгийн жилийн

дундаж агаарын температур  $7.4^{\circ}\text{C}$ , хөрсний дундаж температур  $9.6^{\circ}\text{C}$  байна. Агаарын дундаж харьцангуй чийгшил 39.6%, жилд унах нийт хур тунадасны хэмжээ 96.8 мм хүрдэг. Төслийн талбай орчмын салхины дундаж хурд 5 м/с, их хурд 33.2 м/с (2015.08) хүрч салхилж байжээ. Тус бүс нутагт баруун зүгийн салхи зонхилдог. Салхины чиглэлийн давтамж сар бүрээр хоорондоо харилцан адилгүй байна. Агаарын сарын үнэмлэхүй их, бага температурын олон жилийн дундаж хэмжээ нь тухайн орон нутаг дахь боломжит хязгаарыг илтгэдэг. 1976-2014 оны ажиглалтын мэдээгээр үнэмлэхүй хамгийн бага температур нь  $-21.6^{\circ}\text{C}$  (1977.01), үнэмлэхүй хамгийн их температур нь  $34.0^{\circ}\text{C}$  (2000.07) хүрсэн байна. Зуны улиралд хөрсний хамгийн их температур нь  $57^{\circ}\text{C}$  (1999.07), өвлийн улиралд  $-27.1^{\circ}\text{C}$  (1977.01) тус тус ажиглагдаж температурын агууриг  $84.1^{\circ}\text{C}$  хүрсэн.

**Геологийн тогтоц ба геоморфологи:** Дөрвөлж дайрганы орд нь цохиот формац нь хар, хар саарал хүрэвтээр өнгөтэй андези-базальт, андекит, риодакит, риолит, тэдгээрийн туфууд, туф элсэн чулуу, алевролит, туфитээс бүрдэнэ. Нам уулсын тэгшрэл-жижиг толгодын зөөгдөл-элэгдэлийн гадаргуу. Энэ гадаргуугийн илрэх шинж жижиг толгод элсэрхэг хөндийн захаар налуу хажуутай хэрчигдэлд муу орсон нам уулс толгод юм.

**Ус зүй:** Төв Азийн гадагш урсацгүй ай савд, Монгол орны Галба-Өөш-Долоодын говийн сав газарт тус тус багтана. Энэ ай сав дахь ихэнх голдрил нь түр зуурын урсацтай бөгөөд жилийн ихэнх хугацаанд хуурай байдаг. Хүн амын унданд зөвхөн худгийн ус хэрэглэдэг. Худгуудыг хуурай сайр бараадуулан гаргадаг. Усны түвшин гүн нь 2-3 метр заримдаа 5-7 метр байдаг.

**Хөрсөн бүрхэвч:** Говийн бор болон цөлийн карбонатлаг бор саарал хөрс зонхилон тархсан байдаг. Говийн бор хөрс сайр чулуу элс шавранцар хурдас дээр тогтсон байдаг. Цөлийн карбонатлаг хөрс нь шаварлаг элсэрхэг бүтэцтэй улаан бор өнгийн хурдас дээр тогтвортжсон нимгэн давхрагатай карбонат нилээн агуулсан байна.

**Ургамлан нөмрөг:** Уурхайн талбан нутгийн ургамлын аймаг нь Төв Азийн их бүсийн говийн төв бүсийн зүүн өмнөд хэсгийг төлөөлнө. Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар зүүн говийн цөлөрхөг талын Галбын говийн дэд мужид хамаарагддаг. Тус муж нь зүүн болон хойд талаараа Монголын чийглэг тал хээр болох Манжуур, баруун болон өмнөд талаараа Алашаны тэгш өндөрлөгийн цөлөрхөг хээрт хамаарагдана. 2012 оны судалгаагаар төслийн талбайд нийт 29 овгийн, 74 төрлийн, 127 зүйлийн ургамлыг тэмдэглэсэн байна. Төслийн талбайд хийгдсэн судалгааны үр дүнгүүдийг нэгтгэн үзэхэд төслийн талбайд 3 зүйл ховор ургамал бүртгэгдсэн байна

**Амьтны аймаг:** Уурхайн талбай, түүний орчимд оршин амьдардаг, нутагладаг, дайран өнгөрдөг хөхтөн амьтад, шувуу, хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлийн бүрдлийн дэлгэрэнгүй жагсаалт, хамгааллын статус, тэдгээрийн амьдрах орчны ангилал, тус нутагт тохиолдох магадлал, зэргийг үндэслэн оруулсан. Оюу Толгой төсөл хэрэгжиж буй Ханбогд сумын нутаг хөхтөн амьтдын төрөл зүйлээр баялаг бөгөөд бүс нутгийн болон олон улсын хэмжээнд ховордож буй тууртан амьтад болох хулан адuu, хар сүүлт зээр, цагаан зээр тархан байршдаг.

**Нийгэм, эдийн засаг:** Оюу Толгой уурхайн талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд Улаанбаатар хотоос 550 км зийтай

Даланзадгад хотоос 280 км зайдай оршдог. Өмнөговь аймаг нь 2018 оны байдлаар нийт 66,722 хүн бүртгэгдсэнээс Ханбогд суманд 8,632 хүн нь бүртгэгдсэн байна.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн дайрга олборлох БОНБНУ-ээр төслийн гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байдаг .

**Хүснэгт 4. Төслөөс байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

Байгаль орчны үзүүлэлтүүд	Ил уурхайн ашиглалтын үеийн сөрөг нөлөөлөл	
	Сөрөг нөлөөлөл	Эрэг нөлөөлөл
<b>Экологи орчин</b>		
1. Усны гидробионт	+	
2. Хөрсний микроорганизм	++	
3. Амьтдын тархац нутаг	+	
4. Ургамлын бүлгэмдэл	+++	
<b>Физик орчны өөрчлөлт, бохирдол</b>		
5. Усны чанар, нөөц /ундны ус/	+	
6. Агаар орчны тоосжилт	+++	
7. Хөрсний бохирдол	++	
8. Хөрсний эвдрэл, элэгдэл	+++	
9. Дуу, чимээний нөлөөлөл	+	
10. Цацрагийн нөлөөлөл	+	
<b>Байгалийн нөөц, ашиглалт</b>		
11. Газар ашиглалт	+	
12. Ховор ургамал	+	
13. Ан, амьтан	++	
14. Бэлчээр, хадлан	+	
15. Газар тариалан		
16. Ашигт малтмалын нөөц	++	
<b>Байгалийн гамшиг, хүний буруутай үйл ажиллагаа</b>		
17. Газар хөдлөл	+	
18. Хээрийн түймэр, үер, шороон шуурга	+	
19. Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй осол	++	
<b>Нийгэмд үзүүлэх нөлөөлөл</b>		
20. Эрчим хүчний хангамж		+
21. Усан хангамж		+
22. Шинээр ажлын байр бий болох		+++
23. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл		+++
24. Нүүлгэн шилжүүлэх асуудал гарах эсэх		
25. Хүн амын орлого өөрчлөгдөх		++
26. Хотруу чиглэсэн төвлөрөлийг сааруулах		+
<b>Эдийн засаг, байгаль орчин</b>		
27. Цалин, орлого		+
28. Улс, орон нутгийн төсөв оруулах татвар хураамж		+++
29. Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх		+
30. Орон нутагт шинээр ажлын байр нэмэгдэх		+++
31. Ядуурлыг бууруулах		+
32. Газар ашиглалт нэмэгдэх		++

Байгалийн үзэсгэлэн төрх байдал		
33. Байгалийн үзэмж доройтох	+	
34. Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	+	
35. Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх		
Түүх, археологи, соёлын өв дурсгалт зүйл		
36. Түүхийн дурсгалт зүйлд нөлөөлөх		
37. Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх		

+++ - их, ++ - дунд, + - бага зэрэг, хоосон бол тухайн объектод нөлөөлөлгүй гэж үзнэ.

Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нийт 37 үзүүлэлтийг сонгон авснаас хөрсний микроорганизм, амьтдын тархац нутаг, агаар орчинд тоос үүсгэх, хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл, ойр орчинд дуу чимээ ихсэх, газар ашиглалт, бэлчээр хомсдуулах, байгалийн түүхий эдийн нөөц багасах, үер ус орж голын сайр гольдрил өөрчлөгдөх, уурхайн үйл ажиллагаатай холбоотой осол аваарь гарах, байгалийн төрх байдал ландшафт өөрчлөгдөх зэрэг сөрөг нөлөөллүүд их, дунд, бага зэргийн эрчимтэйгээр нөлөөлж болзошгүй байна. Харин байгалийн түүхий эрдэс баялагийг бүтээн байгуулалтын ажилд ашиглахад бэлэн болгох, орон нутгийн иргэдэд ажлын байр шинээр бий болгох, улс орон нутгийн төсөвт татвар хураамж төлөх, ядуурлыг бууруулах зэргээр нийгэмд эерэг нөлөө үзүүлж болохоор байна.

**Хүснэгт 5. Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн магадласан жагсаалт**

№	Нөлөөллийн эх үүсвэр	Хэлбэр	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ			Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөллийн зэрэг
					Хөрсөн бүрхэвч	Хамрах хүрээ	Нийт оноо				
<b>Хөрсөн бүрхэвч</b>											
1.	Уурхайн карьеер, овоолго	Онцгой их эвдрэл үүсэх	10	3	1	5	19	76	Их		
2.	Ажилчдын тосгон, гал зуух	Элэгдэл талхлагдал үүсэх, бохирдох	4	2	1	3	10	40	Дунд		
3.	Авто тээврийн хэрэгсэл (зам)	Элэгдэл, эвдрэл үүсэх	8	2	1	4	15	60	Дунд		
4.	Авто бааз, засварын газар	Элэгдэл, эвдрэл бохирдол үүсгэх	6	3	3	3	15	60	Дунд		
5.	Тэсрэх материалын агуулах	Элэгдэл, эвдрэл үүсгэх	4	1	1	1	7	28	Бага		
6.	Бутлуур, ангилан ялгах хэсэг	Элэгдэл, эвдрэл, тоосжилт үүсгэх	6	3	3	2	14	56	Дунд		
7.	Цахилгааны под станц	Элэгдэл, эвдрэл үүсгэх	4	1	1	1	7	28	Бага		
8.	Ажилчдын халуун усны газар, ОО	Нянгийн бохирдол үүсгэх	6	3	3	2	14	56	Дунд		
9.	Уурхайн нам даралтын зуух	Элэгдэл, эвдрэл үүсгэх	6	3	3	2	14	56	Дунд		
10.	Ахуйн хог хаягдлын цэг	Бохирдол үүсэх	2	1	1	2	6	24	Бага		
<b>Үргамлан нэмрөг</b>											
11.	Байгалийн ургамалжил устах	Хайрга олборлох, овоолгүүд болон бусад барилга байгууламжуудыг байгуулах, ашиглах зэргээс	8	2	1	4	15	60	Дунд		

12.	<b>Ургамлын ургах чадварыг алдагдуулах</b>	Машин техникийн хөдөлгөөн, хог хаягдал ба шороо, овоолгуудаас бий болох тоосжилт нь ургамлан бүрхэвч дээр буух хуримтлагдах	8	2	1	4	15	<b>60</b>	Дунд
13.	<b>Үрт үндэстэй, олон наст ургамалд нөлөөлөх</b>	Бага гүний усны татралт нь гүний усаар тэжээгддэг ургамлын ургалт саарах, мөхөх улмаар ургамал нөмрөгийн доройтолд өртөх	6	2	1	4	13	<b>52</b>	Дунд
14.	<b>Гадаргын устай холбоотой ургамалжил мөхөх</b>	Хүчтэй аадар борооны гадаргын урсац, нэл угаагдлаар ургамлан нөмрөг бохирдох, ургамлан бүрхэц багасах, зүйлийн бүрэлдэхүүний тоо цөөрөх, улмаар ургамлан нөмрөг устаж болзошгүй	4	2	1	2	9	<b>36</b>	Дунд
<b>Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл</b>									
15.	<b>Тоосжилт</b>	Дайрга олборлолт, уурхайн ашиглалтаас үүсэх тоосжилт	8	2	1	5	16	<b>64</b>	Дунд
16.		Уурхайн гадаад дотоод тээвэрлэлтээс үүсэх тоосжилт	8	2	1	4	14	<b>60</b>	Дунд
17.		Ангилан ялгах, шигших	8	2	1	5	12	<b>48</b>	Дунд
18.		Машин техникийн түлш шатахуунаас үүсэх хий	4	2	1	2	9	<b>36</b>	Дунд
19.	<b>Уурхайн нам даралтын зуух</b>	Хорт хийнүүд, Угаарын хий	4	2	3	2	11	<b>44</b>	Дунд
20.	<b>Авто машин, механизмийн хор утaa</b>	Хорт хийнүүд үүсгэх	6	3	3	2	14	<b>56</b>	Дунд
<b>Амьтны аймаг</b>									
21.	<b>Амьтдын амьдрах орчин</b>	Доройтох, хязгаарлагдах	4	3	1	3	12	<b>44</b>	Дунд
22.	<b>Амьтад дайжих</b>	Дуу чимээ, тоос шороо	8	2	1	4	15	<b>60</b>	Дунд
23.	<b>Идэш тэжээлийн хомсдол</b>	Амьтдын идэш тэжээл эрж олох газар өөрчдөгдхөх, хумигдах	6	2	1	3	12	<b>48</b>	Дунд
24.	<b>Амьтдын тоо толгой буурах</b>	Амьтдын орогонон нүх, үүр, үржлийн газар уурхайн ашиглалтанд өртөх	8	2	1	3	14	<b>56</b>	Дунд
<b>Үр дүн</b>									<b>50.3</b>

### **ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

**Зорилго, зорилт:** Төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2021 онд “Грийн солюшн консалтинг” ХХК-ийн боловсруулсан Дөрвөлж барилгын чулууны орд дайрга олборлох төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангаар тодорхойлогдсон төсөлт хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

**Хамрах хүрээ:** SGMV-00010 тусгай зөвшөөрлийн талбайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төслүүдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно.



## СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний

СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	ХАМРАХ ХҮРЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА	ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	ЗАРДАЛ /төг/	БАРИМТЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ СТАНДАРТ
<b>АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ</b>						
Олборлолтын явцад карьеерын ханыг ухах нураах ачих тээвэрлэх овоолгонд байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсч агаарын чанарт нөлөөлөх	10м/с-ээс дээш хүчтэй салхитай үед олборлолтын үйл ажиллагааг түр зогсоох	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	-	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ууршимтгай органик нэгдэлүүд агаарт дэгдэж тухайн орчны агаар болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдэж ажиллах асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах саармагжуулах хэрэгсэлийн талбайд бэлэн байлгах	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	1 500 000	/ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/

Хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр сүл шороо үүсч, тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх	Уурхайн замд хурдны хязгаар тогтоох /40 км/ цагаас хэтрэхгүй байх, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах цаашид засч сайжруулах	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	500 000	
	Уурхайн гол замуудын сүлжээ маршрутыг тогтоох, сайжруулсан хайрган хучилттай болгох цаашид арчилж тордох	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	500 000	
Машин техник тооног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарагх утаа тортог бусад элемент зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Тээврийн хэрэгсэлүүдэд Монгол улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд /бензин, дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид/ болон олон улсын холбогдох стандартуудын дагуу хяналт хийж түүнд нийцүүлэх	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	-	
	Ашиглагдаж буй машин техникиээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах техникийн үзлэг засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	-	

**ГАЗРЫН ГАДРАГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

Дайрга олборлолтын хэмжээ нэмэгдсэн үед хөрс хуулалт хийгдэх ба тухайн талбайн хөрсөн бүрхэвч гадаргаас зайлцуулагдах	Олборлолт нэмэгдэх бүрт шимт хөрсийг хуулж тусгай талбайд стандартын дагуу байршуулж хэлбэржүүлж хамгаалах	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	-	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БОНБҮ тухай хууль, Хөрс хамгаалах,
---	--	---------------	-------------------------------------	----------------------	---	--

Машин техникийн тос тосолгооны материал асгарч хөрс бохирдуулах	Техникийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбай / засварын цех/-д байрлуулж засах	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	-	цэлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдхөн дээд хэмжээ
Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдох	Засварын цех, шатах тослох материалын агуулах, хуучин тос хадгалах цэг зэргийг цементлэх засаж сайжруулж байх	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	3 000 000	Энэ стандартаар Монгол орны нутаг дэвсгэр дээрх хөрсөнд агуулагдаж болох бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдхөн (хүлцэх) дээд хэмжээг тогтоох бөгөөд тус стандартад заасан хэмжээнээс давсан тохиолдолд тухайн хөрсийг бохирдолд орсон гэж үзнэ. MNS 5916 : 2008 Газар шорооны ажлын үед үржил, шимт хөрс хуулалт, хадгалалт
Уурхайн гал тогоо, угаалгаас гарах шингэн хаягдал мөн хоолны үлдэгдэл хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр хөрс бохирдох	Хог хаягдалыг зориулалтын саванд хадгалж сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаяж байх	Уурхайн тосгон	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	-	Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж био бэлдмэлээр тогтмол ариутгах цаашид байгаль орчинд халгүй зайлцуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх
	Уурхайн тосгон	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	-		

#### УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Ил уурхайгаас хуулах хөрсийг автосамосвалаар тээвэрлэх ба хүнд даацын машин механизмын нөлөөгөөр ургамалан нөмрөг талхлагдах ургах чадвараа алдах	Уурхайн авто замуудыг дулаааны улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	-	Байгаль орчны багц хуулиуд, Байгалийн ургамлын тухай хууль
---	--	---------------	-------------------------------------	----------------------	---	--

#### УСНЫ НӨӨЦ ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Уурхайн ухаш үүсэх далан байгуулах суваг шуудуу татах, хөрс өвдрэлд оруулах зэргээр газрын гадаргын хэлбэр дүрсийг өөрчилсөнөөр гадаргын урсацын байгалийн унаган тогтоц өөрчлөгдөх	Бусад шаардлагагүй тохиолдолд гадаргын хэлбэр төрх байдлыг өөрчлөхгүй байх	Уурхайн бүсэд	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	-	Усны тухай хууль
	Ажилчдад усыг хэмнэлттэй хэрэглэхийг уриалж, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг гал тогоо, угаалтуур зэрэг газруудад байршуулах	Уурхайн тосгон	Төсөл хэрэгжих бүх хугацааны туршид	Өгөөмөр гавилууд ХХК	-	

#### АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хөрсөнд үүрлэдэг жижиг хөхтөн амьтад бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах сүйтгэгдэх	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж амьтадын үүр сүйтгэхгүй байх	Уурхайн ойр орчимд	Төслийн хугацаанд тогтмол	Өгөөмөр гавилууд ХХК	-	Амьтны тухай хууль, бусад БО-ны багц хуулиуд
	Олборлолтын үед үүссэн ашиглагдахгүй нүх, цооног, овоолсон шороо зэргийг тухай бүрт нь булж, тэгшлэх	Уурхайн ойр орчимд	Төслийн хугацаанд тогтмол	Өгөөмөр гавилууд ХХК	-	
Уурхайн орчимд тохиолдог амьтадын тохиолдоц багасах	Уурхайн орчимд амьтадын тооллого ажиглалт мониторингийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байх	Уурхайн ойр орчимд	Төслийн хугацаанд тогтмол	Өгөөмөр гавилууд ХХК	1000 000	

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал 7.000.000 төгрөг

## НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн

АРГА ХЭМЖЭЭ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАМРАХ ХҮРЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	НИЙТ ЗАРДАЛ /төг/	БАРИМТЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ СТАНДАРТ
Техникийн нөхөн сэргээлт	Шимт хөрсийг стандартын дагуу хуулж овоолон хадгалах	Уурхайн олборлолтын талбайд	Өгөөмөр гавилууд ХХК	1960000	MNS5916-2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт харс хуулалт, хадгалалт
	Ашиглалтгүй болсон зам талбайг нөхөн сэргээх Ажилчдын тосгоныг засаж тохижуулах ногоон байгууламж байгуулах	Уурхайн бүсэд	Өгөөмөр гавилууд ХХК	1400000	MNS4919-2000 Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс MNS5918-2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага
	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 500 мод тарих	Ханбогд сумын нутагт ЗДТГ-с хувиарласан талбайд	Өгөөмөр гавилууд ХХК	1400000	
Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны нийт зардал <b>4.760.000 төгрөг</b>					

### Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын талбай болон түүний эргэн тойрон хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологийн дурсгал олдоогүй. Иймд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний талаар БОМТ-нд тусгагдаагүй болно.

## ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Өгөөмөр гавилууд” ХХК нь өмнийн говийн биологийн олон янз байдалд эерэг ахиу нөлөө үзүүлэхийг зорилготой ажилладаг билээ. Энэхүү зорилгodoо уурхайн хаалтын үед хүрсэн байхаар зорьж байна. Үйл ажиллагаа явуулж буй бус нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасгах зарчмыг баримтална. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа юун түрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгдэнэ. Биологийн олон янз байдлын стратегид дээрх сөрөг нөлөөллийг бууруулах шатлалыг дараах байдлаар тус тус тодорхойлсон байдаг.

1) Зайлсхийх - “Зайлсхийх арга хэмжээнүүд нь биологийн олон янз байдалд бодит нөлөөлөл үүсэхээс өмнө буюу олборлолтын болон баяжуулалт зэрэг уурхайн үйл ажиллагааг өхлүүлэхээс урьтан менежментийн өөрчлөлт хийх эсвэл тухайн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээнүүд юм. Үүнд өмнөх төлөвлөгөө үйл ажиллагаа, арга хэмжээг өөрчлөх шийдвэрүүд багтана”.

2) Багасгах – “Багасгах арга хэмжээнүүд нь аль хэдийн эхэлсэн олборлолтын болон боловсруулах үйл ажиллагааны үр дүнд биологийн олон янз байдалд учирч болох хохирлыг багасгаж болох арга хэмжээнүүд юм”.

3) Нөхөн сэргээх – “Нөхөн сэргээх арга хэмжээнүүд нь уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар нутгуудад аюулгүй, тогтвортой газрын төрх, тогтцыг бий болгох бэлтгэл ажлууд, ургамалжуулж амьдрах орчныг дахин сэргээх ажил. Амьдрах орчныг сэргээх арга хэмжээ нь нөхөн сэргээлтээс бага зэрэг ялгаатай тал бий, энэ нь тухайн амьдрах орчныг эвдрэлд өртөхөөс өмнөх бүхий л нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ”.

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

АРГА ХЭМЖЭЭ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАМРАХ ХҮРЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	НИЙТ ЗАРДАЛ /төг/	БАРИМТЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ СТАНДАРТ
Заган ой экосистемийг хамгаалах доройтолоос урьдчилан сэргийлэх	Заган ойг нөхөн сэргээхтэй холбоотой сургалт сурталчилгааны ажилд оролцох	Ханбогд сум	Өгөөмөр гавилууд ХХК	3000 000	БОНХАЖЯ-ны А-117-р тогтоол “Байгаль орчинд нөлөөлөлх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал”
	Биотехникийн арга хэмжээ зохион байгуулах	ГБДЦГХЗ, ЗДТГ	Өгөөмөр гавилууд ХХК	3109 000	
	ГБДЦГ-н менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан заган ойн нөхөн сэргээхтэй холбогдох ажилд оролцох	ГБДЦГХЗ	Өгөөмөр гавилууд ХХК	5000 000	

Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны нийт зардал 11.109.000 төгрөг

## ХОГ ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 9. Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө*

АРГА ХЭМЖЭЭ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАМРАХ ХҮРЭЭ	ХЭРЭГЖҮҮЛ ЭГЧ	НИЙТ ЗАРДАЛ /төг/	БАРИМТЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ СТАНДАРТ
Хатуу хог хаягдлыг зөөж, тээвэрлэх	Уурхайн хог хаягдлыг ангилан цуглуулж, тусгай зөвшөөрөл бүхий ААН-ээр тээвэрлүүлж, зайлзулах	Уурхайн тосгоны хог хаягдал	Өгөөмөр гавилууд ХХК	1 000 000	
Уурхайн орчны эрүүл ахуйг хангах	Хогийг анхан шатанд нь ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдалын хувь хэмжээг нэмэгдүүлэх	Угаалгын газар, бие засах газар Хоолны үлдэгдэл шингэн хаягдал	Өгөөмөр гавилууд ХХК	-	Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хууль болон БО-ны багц хуулиуд, холбогдох дүрэм журам стандартууд
	Уурхайн эдэлбэр талбайн ойр орчимд хог хаягдлын нийтийн цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа зохион байгуулж байх	Уурхайн ойр орчимд	Өгөөмөр гавилууд ХХК	-	
	Зориулалтын хогийн савнуудыг талбайд байршуулах, зохистой хаяж байгаа эсэхэд хяналт тавих	Уурхайн ойр орчимд	Өгөөмөр гавилууд ХХК	500 000	

**Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал 1 500 000 төг**

## ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

*Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

Байгаль орчны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналт шинжилгээ хийх, Сорьц авах цэгийн байршил	Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж	Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал	Зардал /төг/	Үр дүнг нэгтгэх, тайлагнах арга хэлбэр
Агаар орчин	Тоосжилт/ PM10, PM25, PSM/ гадаад дотоод дуу чимээ доргио чичиргээ	Уурхайн ойр орчмоос	Жилд 1 удаа	Лабораторийн шинжилгээний арга	400000	Лабораторын шинжилгээний үр дүнд үндэслэн

	Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд /тоос дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин	Уурхайн ойр орчмоос	Жилд 1 удаа	Лабораторийн шинжилгээний арга		
Хөрсөн бүрхэвч	Хүнд металл, агрохимиин үзүүлэлт, химиин шинж чанар	Ажилчдын тосгон, засварын газар, хогийн цэг орчмоос	Жилд 1 удаа	Лабораторийн шинжилгээний арга	200000	Лабораторын шинжилгээний үр дүнд үндэслэн
	Механик бүрэлдэхүүн чулуу, чийг, амь чийг, эзэлхүүн жин		Жилд 1 удаа	Лабораторийн шинжилгээний арга	200000	
Усан орчин	Усан дахь эрдэс бодисууд, химиин найрлага	Ашигладаг худгаас	Жилд 1 удаа	Лабораторийн шинжилгээний арга	184 000	Лабораторын шинжилгээний үр дүнд үндэслэн
	Усан дахь нян бактерийн судалгаа		Жилд 1 удаа	Лабораторийн шинжилгээний арга		Лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн
Ургамлан номрөг	Хээрийн ажиглалт судалгаа	Төслийн талбайд сонгосон судалгааны цэгт	Жил бүрийн 7-р сард	Хээрийн судалгаа	500 000	Судлаачийн дүгнэлт
Амьтаны аймаг	Туруутан амьтадын байршил нутаг тоо толгой шилжилт хөдөлгөөн мөлхөгчид мэрэгчидийн нягтшил тогтоох	Төслийн талбайд сонгосон судалгааны цэгт	Жил бүрийн 7-р сард	Хээрийн судалгаа	500 000	Судлаачийн дүгнэлт
	Шувуудын нүүдлийн үеэр ажиглалт мониторинг хийх	Төслийн талбайн орчмын уст цэгт	Жилд 1 удаа	Хээрийн судалгаа	-	Ажиглах бүртгэл хөтлөх
<b>Орчны хяналт шинжилгээний нийт зардал 1 984 000 төг</b>						

## 9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

АРГА ХЭМЖЭЭ	ХАМРАХ ХҮРЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА	ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	НИЙТ ЗАРДАЛ /төг/	БАРИМТЛАХ ХУУЛЬ ДҮРЭМ СТАНДАРТ
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаанд агаарын хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Уурхайн хэмжээнд	Тогтмол	Өгөөмөр гавилууд ХХК	-	БО багц хуулиуд, холбогдох дүрэм журам стандарт, Усны тухай хууль, Байгалийн нөөц ашигласан төлбөрийн тухай хууль, ЗГ-н тогтоол, усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай, бусад холбогдох хууль тогтоол, журам,
Уурхайн нийт ажилчдад байгаль орчныг хамгаалах үйлдвэрийн осол гол түймэр үер усны аюул зэргээс урьдчилан сэргийлэх осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалтыг зохион байгуулах, хамруулах	Уурхайн ажилчид	Жилд 1 удаа	Өгөөмөр гавилууд ХХК	-	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17), MNS5078-2001, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй"
Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, ажлын онцлогоос хамааруулан хордлого тайлах хүнс бэлдмэлээр хангаж байх	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	Өгөөмөр гавилууд ХХК	-	MNS ISO 13688 : 2000
Гал унтраах хэрэгслээр уурхай тосгон болон ажлын байрыг бүрэн хангаж, байршуулах	Уурхайн тосгон, оффис	Төсөл хэрэгжих бүх хугацаанд	Өгөөмөр гавилууд ХХК	-	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас-Ерөнхий шаардлага
Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх сургалт, аян, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах	Ханбогд суманд	Жилд 1 удаа	Өгөөмөр гавилууд ХХК	1000000	

Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний нийт зардал 1 000 000 төг

## ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Хүснэгт 11. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

БОЛЗОШГҮЙ АЮУЛ ОСОЛ СӨРӨГ НӨЛӨӨ	НӨЛӨӨЛӨЛӨӨС ЗАЙЛСХИЙХ АРГА ХЭМЖЭЭ	ХАМРАХ ХҮРЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА	ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	НИЙТ ЗАРДАЛ /ТӨГ/
Аянга цахилгаан	Аянга зайлцуулагч ЦС-н байгууламжийн ойролцоо өндөрлөг газруудад суурилуулах, ЦС-ын цахилгаан гүцдэл бүхий тоноглолтуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Төслийн талбайд	Төсөл эхлэхийн өмнө	Өгөөмөр гавилууд ХХК	Уурхайн дотоод төлөвлөлтөөр
Аадар бороо	Уурхайг үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох		Төсөл эхлэхийн өмнө 1 удаа	Өгөөмөр гавилууд ХХК	
Шороон шуурга	Уурхайд онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах		Төслийн хугацаанд	Өгөөмөр гавилууд ХХК	
Үер	Гадаргын усны урсацыг өөрчлөх үерийн далан шуудуу татах хүмүүст үерийн анхааруулга өгч хүний амь нас дэд бүтцийг хамгаалах		Хур борооны улиралаас өмнө	Өгөөмөр гавилууд ХХК	
Халдварт өвчин	Өндөр эрсдэлтэй амьтадтай /шуувуд/харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх / амны хаалт гэх мэт/		Төслийн талбайд	Өгөөмөр гавилууд ХХК	
Нефт болон химийн аюултай бодис асгарах	Ашиглалт тээвэрлэлт хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай		Төсөл хэрэгжих бус нутагт	Өгөөмөр гавилууд ХХК	1000000
Ажлын байрны осол гэмтэл	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт семнарыг тогтмол зохион байгуулж хамруулах		Төсөл хэрэгжих хугацаанд	Жил бүр	1000000
	Ажиллагсадыг хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэглэлээр хангах		Төсөл хэрэгжих хугацаанд	Жилд 2 удаа	2500000
	Ажиллагсадыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах			Жил бүр	1500000

Осол эрсдэлийн менежментийг төлөвлөгөөний нийт зардал 5 000 000 төгрөг

**Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийг  
нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь**

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтын дагуу гаргаж, Өмнөговь аймгийн Байгаль орчны газарт хүргүүлнэ.

**Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч  
оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь**

<b>БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд</b>	<b>Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр</b>	<b>Мэдээллийн агуулга</b>	<b>Хугацааны төв</b>	<b>Хэлэлцүүлгээр санал авах чиглэл</b>
Өмнөговь аймгийн Байгаль орчны газар	БОМТ-ны биелэлтийн тайлангийн эх хувь албан бичгийн хамт	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг баталгаажуулах
Ханбогд сумын Засаг даргын тамгын газарт	БОМТ-ны биелэлтийн тайлангийн эх хувь албан бичгийн хамт	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах

